

ДОТООДЫН

**ЗАХ ЗЭЭЛИЙН ДОЛОО
ХОНОГИЙН ТОЙМ**



2025.10.20

Дотоодын зах зээлийн онцлох мэдээ

ТОВЧ

- Цаг агаарын нөхцөл байдлаас шалтгаалан инфляц 0.4-0.6 хувиар өсөж магадгүй
- Нүүрс, төмрийн хүдрийн эрэлт буурах магадлалтай байна
- Коксжих нүүрсний эрэлт 2026 онд 1.5% буурах хүлээлттэй ба эрэлтээ давсан их овоолго үүссэн байна
- Дотоодын хувьцаануудын ханш буурлаа

МХБ-ийн индексийн өгөөж

Индекс	Долоо хоног	Сар	Жил
ТОП 20	-0.89%	1.93%	25.47%
MSE A	-1.14%	7.58%	20.27%
MSE B	0.89%	0.2%	34.89%

2025/10/13 – 2025/10/17

Идэвхтэй арилжаалагдсан үнэт цаас

Симбол	Үнийн дүн
QPAY	2,070,875,657.97
ERDN	363,157,960.00
KHAN	351,295,632.00
TTL	93,696,200.00
APU	92,799,147.64

2025/10/13 – 2025/10/17

Өндөр өсөлттэй үнэт цаас

Симбол	Хаалтын ханш	Өсөлт %
BDS	2,561.00	55.31%
EAZ	396.00	14.78%
TNGR	5,600.00	14.29%
ERS	17,250.00	14.16%
TCK	29,400.00	12.99%

2025/10/13 – 2025/10/17

2025 он 10-р сарын 20

Зах зээлийн
үнэлгээ тэрбум ₮

13,175

ТОП-20 индекс

49,119

MSE A

18,934

MSE B

14,568



МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

ДНБ өсөлт

5.6%

2025 - III улирал

Инфляц

9.0%

2025-09 сар

ГВУН(сая\$)

5,874.52

2025-09 сар

Бодлогын

хүү

12.0%

ЗГ-ын бондын

өгөөж

6.6%

USD/MNT

3,594.28

2025-10-19

 **Эдийн засгийн мэдээлэл****ЦАГ АГААРЫН НӨХЦӨЛ БАЙДАЛ МУУДАХ НЬ МАНАЙ УЛСЫН ИНФЛЯЦАД НӨЛӨӨЛӨХ ҮҮ?**

2025 оны 9-р сард Монгол Улсын хэмжээнд хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 9.0%-иар өссөн нь инфляц одоогоор Төв банкны зорилтот түвшнээс давсан хэвээр байгааг харуулж байна. Эдийн засагчдын үзэж буйгаар ирэх 2026 оны эхний хагаст хүнсний бүтээгдэхүүний улирлын өсөлт болон төрийн зохицуулалттай үйлчилгээний үнийн нэмэгдэл инфляцыг богино хугацаанд дахин өсгөж болзошгүй аж. Манай улсын инфляцын бүтэц дотор хүнсний үнийн өсөлт 40%-иас дээш жинтэй. Тиймээс ургацын гарц, махны нийлүүлэлт, цаг агаарын нөхцөлд үнийн түвшин маш мэдрэмтгий байдаг.

2025 оны хавар, зун хуурай, гандуу байсан нь ирэх өвлийн өвөлжилт хүндрэх эрсдэл нэмэгдүүлж байна. Хэрэв энэ хувилбар биелбэл:

- Ургац хураалт багасаж, гурил, гурилан бүтээгдэхүүний үнэ өснө.
- Зудын улмаас малын хорогдол нэмэгдэж, махны нийлүүлэлт буурна.
- Үүнтэй уялдан нийтийн хоолны үнэ өсөж, өрхийн хэрэглээний зардал нэмэгдэнэ.

Эдгээр нь нийлээд суурь инфляцын түвшинг 0.4–0.6 нэгж хувиар өсгөх магадлалтай гэж эдийн засагчид тооцоолжээ. Монголбанк 2026 онд инфляцыг зорилтот 6%-н интервалд барихыг зорьж байгаа. Гэвч цаг агаарын сөрөг нөлөөлөл хүчтэй үргэлжилбэл инфляц богино хугацаанд 10%-д хүрэх магадлалтай.

ЭКСПОРТЫН ГОЛ ТҮҮХИЙ ЭДИЙН БҮТЭЭГ ДЭХҮҮНИЙ ҮНИЙН ХАНДЛАГА

2025 оны 9-р сарын байдлаар дэлхийн түүхий эдийн зах зээлийн эрэлт ба нийлүүлэлтийн тэнцвэргүй байдал, тарифын бодлого, байгалийн хүчин зүйлс, геополитикийн эрсдэл зэргээс хамаарч тогтворгүй, өндөр савалгаатай байлаа. 2026 оноос ногоон эдийн засгийн хөрөнгө оруулалт, сэргээгдэх эрчим хүчний эрэлт өсөх нь зэс болон газрын тосны үнийг дэмжих, харин нүүрс, төмрийн хүдэр эрэлт талаасаа буурах хандлагатай байх төлөвтэй.

Зэс: 2025 оны 2-р улиралд зэсийн дундаж үнэ тонн тутамд 9,498 ам.долларт хүрч, өмнөх улирлын төсөөллөөс арай өндөр түвшинд хаагдлаа. Гэсэн хэдий ч, АНУ-ын Ерөнхийлөгч Дональд Трамп 7-р сард зэсийн импортод 50%-ийн тариф тогтоох шийдвэрээ зарласнаар зах зээл богино хугацаанд хүчтэй савласан. Хожим энэхүү тариф зөвхөн хагас боловсруулсан зэсийн импортод хамаарна гэж мэдэгдсэн нь айдсыг намжааж, үнийн тогтворжилт бий болгожээ.

Коксжих нүүрс: Хятадын дотоод олборлолт давамгайлж, үнэ огцом буурсан. 2025 оны 2-р улиралд коксжих нүүрсний хилийн үнэ 60 ам.доллар/тн болж, өмнөх улирлын төсөөллөөс 17.2%, өнгөрсөн жилийнхээс 42.4%-иар буурлаа. Энэ нь БНХАУ-ын дотоодын нүүрсний олборлолт нэмэгдэж, импортын эрэлт огцом буурсантай холбоотой.

Төмрийн хүдэр: Хятад дахь гангийн эрэлт суларч, үнэ уналтын дараа богино хугацаанд сэргэв. Төмрийн хүдрийн үнэ 2-р улиралд 91 ам.доллар/тн-д хүрч, сул эрэлт, гангийн үйлдвэрлэлийн бууралттай холбоотойгоор огцом буурсан. Гэхдээ улирлын сүүлээр уул уурхайн үйл ажиллагааны тасалдал, үер, хяналт шалгалт нэмэгдсэнээр нийлүүлэлт багасч, үнэ 7-р сард 96 ам.доллар/тн болж түр хугацаанд өсжээ.



Зах зээлийн мэдээлэл

ТОП-20 ИНДЕКСИЙН ГҮЙЦЭТГЭЛ ДАХИН СЭРГЭЛЭЭ


График 1. ТОП-20 индексийн ханшийн өөрчлөлт



ТОП-20 индекс 2025 он гарснаар 6.23 хувиар унаад байна. Компаниудын орлого эхний хагас жилд өссөн ч гэсэн цэвэр ашиг өнгөрсөн оны мөн үеэс буурсан үзүүлэлттэй байлаа. Ханш 46,300 түвшин рүү үргэлжлэн унах магадлал өндөр бөгөөд 46,300 хүчтэй дэмжлэгийн бүс болж байна. Энэ оны сүүлийн улиралд индекс хүчтэй өсөх магадлалай.

ХАС БАНК ХК-ИЙН АШИГ БУУРСАН Ч ХӨРӨНГИЙН ХЭМЖЭЭ ӨСӨВ

График 2. ХАС хувьцааны ханшийн өөрчлөлт




Хас банк ХК 2025 оны 3-р улирлын санхүүгийн гүйцэтгэлээ танилцууллаа. Тайлангаас харахад банкны нийт хөрөнгө 25.7%-иар өсч 7 их наяд төгрөг, харин өөрийн хөрөнгө 20 гаруй хувиар нэмэгдэж 827.4 тэрбум төгрөгт хүрсэн байна.

Гэсэн хэдий ч ашигт ажиллагаа өмнөх оны мөн үеэс буурч, цэвэр ашиг 3%-иар буурч 124.9 тэрбум төгрөг болжээ. Нэгж хувьцаанд ногдох ашиг (EPS) нь 118.8 төгрөг байна. Энэ нь 2020 оноос хойш анх удаа Хас банкны 3-р улирлын ашиг буурсан үзүүлэлт юм.[MSE:ХАС] хувьцааны ханш оны эхнээс хойш 10 орчим хувиар өссөн бөгөөд хувьцааны ханшийг дэмжих зорилгоор эргүүлэн худалдан авах хөтөлбөр хэрэгжүүлэхээ мэдэгдээд байгаа билээ.

ДОТООДЫН ХУВЬЦААНД ХЭЗЭЭ ХӨРӨНГӨ ОРУУЛАХ ВЭ?

ТОП-20 индексийн сарын дундаж хэлбэлзэл (2015-2025)



Монголын ТОП-20 индексийн дундаж хэлбэлзлээс харахад 1-3 сар, 7-9 сар, 12 саруудад өсөлт давамгайлдаг байна.

Ямар стратеги баримтлах вэ?

- Ногдол ашиг хүртэхийг зорьж буй бол 1-3 сард хувьцаа худалдаж авах нь тохиромжтой.
- Хямд үнээр хувьцаа авах боломж хайж байгаа бол 4-5 сард зах зээлийн уналтыг ашиглах хэрэгтэй.
- 7-9 сард зах зээл өсөх магадлалтай тул эрт худалдан авч, өсөлтийг ашиглах боломжтой.
- Жилийн эцэст (12-р сар) дунд хугацааны өсөлт ажиглагдах хандлагатай тул урт хугацааны хөрөнгө оруулалтад тохиромжтой үе.

ВАЛЮТЫН ХАНШИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ

Хэрэв нүүрсний үнэ 10%-иар буурч экспортын орлого 800 сая ам.доллараар багасна гэж үзвэл: 2026 онд инфляц 0.7 нэгж хувиар нэмэгдэхтэй уялдан төгрөгийн ханш ам.долларын эсрэг 3-5% орчим сулрах магадлалтай.

График 1. Төгрөгийн ам.доллартай харьцах ханш

